



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

Албан уулзалтын тухай

Олон улсын Иргэний нисэхийн тухай Чикагогийн Конвенцийн 13 дугаар Хавсралтын хүрээнд байгуулсан "Хамтран ажиллах санамж бичиг-ийн үр дүнг хэлэлцэх, сайжруулах болон хамтын ажиллагааны талаар Оросын Холбооны улсын Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах байгууллага /Улс хоорондын нисэхийн хороо МАК/-ийн дарга О.Г. Сторчевой манай улсад ажлын айлчлал хийх болсонтой холбогдуулан ТУШААХ нь:

1. Хоёр талын хамтын ажиллагааны болон "Хамтран ажиллах санамж бичиг-ийн шинэчлэн байгуулах талаар санал боловсруулж танилцуулах, шаардлагатай бол гэрээний төслийг бэлтгэхийг шинжлэн шалгах тасгийн дарга, ахлах шинжээч Х.Наранхүүд үүрэг болгосугай.

2. Ажлын айлчлалын хүрээнд хийгдэх уулзалт, хүлээн авалтанд бэлтгэх ажлыг зохион байгуулах гарах зардлын тооцоо төсвийг боловсруулж баталгаажуулахыг Захиргаа, судалгааны тасгийн дарга, шинжээч П.Гэрэлчимэгт үүрэг болгосугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Ж.ЦОЛМОН



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 4/02

Улаанбаатар хот

Хариуцлагатай жижүүр томилох тухай

“Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүд, тэдгээрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Сар шинийн баяраар нийтээр амрах 2024 оны 02 дугаар сарын 10-ний өдрөөс 02 дугаар сарын 13-ны өдрийг хүртэлх 3 хоногийн хугацаанд Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албанаас ажиллах хариуцлагатай жижүүрийн ажлын удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Баярын өдрүүдэд үндсэн үүрэгт ажил болон нислэг техникийн осол, зөрчлийн талаар дүрмийн дагуу мэдээ, мэдээллээр хангахыг хариуцлагатай жижүүрт үүрэг болгосугай.
3. Баярын өдрүүдэд ажилласан хариуцлагатай жижүүрт хяналт тавьж ажиллах, энэ хугацаанд гарсан мэдээ, мэдээллийг нэгтгэж танилцуулахыг Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны ахлах шинжээч Х.Наранхүүд даалгасугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Handwritten signature of J. Cholmon

Ж.ЦОЛМОН



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

Шинжлэн шалгах багийг томилох тухай

Иргэний нисэхийн тухай Монгол улсын хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, Иргэний нисэхийн багц дүрэм 203-ын 8.1 дэх заалт, НТОЗШША-ны дүрмийн 2.2-ын заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. МИАТ ХК-ийн JU-1088 бүртгэлийн дугаартай Б-737-800 маягийн агаарын хөлөг 2024.02.27-ны өдөр Хонконг-УБ чиглэлийн нислэгийн үед битүүмж алдагдсан шалтгааныг тогтоох шинжлэн шалгах багийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Шинжлэн шалгах багийн ахлагч:

Х.Наранхүү, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны ахлах шинжээч

Гишүүд: Ч.Буянбадрах, Нислэгийн шинжээч

Ч.Шинэбаяр, Техникийн шинжээч

П.Гэрэлчимэг, Техникийн шинжээч

С.Баттулга, Бүртгэл, судалгааны мэргэжилтэн

2. Шинжлэн шалгах ажиллагааг дүрэм, зааврын дагуу хийж гүйцэтгэхийг багийн ахлагч (Х.Наранхүү)-д үүрэг болгосугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Ж.ЦОЛМОН



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 4/06

Улаанбаатар хот

Хариуцлагатай жижүүр томилох тухай


“Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүд, тэдгээрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Бурхан багшийн их дүйчин өдөр нийтээр амрах 2024 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 08 цагаас 05 дугаар сарын 24-ний өдрийн 08 цаг хүртэлх 1 хоногийн хугацаанд Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албанаас ажиллах хариуцлагатай жижүүрийн ажлын удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Баярын өдөр үндсэн үүрэгт ажил болон нислэг техникийн осол, зөрчлийн талаар дүрмийн дагуу мэдээ, мэдээллээр хангахыг хариуцлагатай жижүүрт үүрэг болгосугай.

3. Баярын өдөр ажилласан хариуцлагатай жижүүрт хяналт тавьж ажиллах, энэ хугацаанд гарсан мэдээ, мэдээллийг нэгтгэж танилцуулахыг Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны ахлах шинжээч Х.Наранхүүд даалгасугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Ж.ЦОЛМОН



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/07

Улаанбаатар хот

Хариуцлагатай жижүүр томилох тухай

Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгууль болох гэж байгаатай холбогдуулан агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааг явуулах, өндөржүүлсэн бэлэн байдалд байлгах, Сайдын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын дагуу ажлын хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгууль болох гэж байгаатай холбогдуулан 2024 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 08 цагаас 06 дугаар сарын 28-ны өдрийн 08 цаг хүртэлх 28 хоногийн хугацаанд Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албанаас өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах хариуцлагатай жижүүрийн ажлын удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тухай өдрүүдэд үндсэн үүрэгт ажил болон нислэг техникийн осол, зөрчлийн талаар дүрмийн дагуу мэдээ, мэдээллээр хангаж, өндөр хариуцлагатай ажиллахыг жижүүрт үүрэг болгосугай.

3. Хариуцлагатай жижүүрт хяналт тавьж ажиллах, энэ хугацаанд гарсан мэдээ, мэдээллийг нэгтгэж танилцуулахыг Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны ахлах шинжээч Х.Наранхүүд даалгасугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ

Ж.ЦОЛМОН





НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

Шинжлэн шалгах багийг томилох тухай

Иргэний нисэхийн тухай Монгол улсын хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, НТОЗШША-ны дүрмийн 2.1., 2.2 заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Төв аймгийн Эрдэнэ сумын Мандал амралтын районд Монгол улсын JU-8889 бүртгэлийн дугаартай, иргэн Чойжилжавын Гэрэлт-Одын Savage Shock Ultra маягийн хэт хөнгөн агаарын хөлөг осолдсон шалтгааныг тогтоох шинжлэн шалгах багийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Шинжлэн шалгах багийн ахлагч:

Ч.Буянбадрах, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны нислэгийн шинжээч

Гишүүд: Ч.Шинэбаяр, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны техникийн шинжээч

Г.Ганхуяг Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны нислэгийн хөдөлгөөний шинжээч

2. Шинжлэн шалгах ажиллагааг дүрэм, зааврын дагуу хийж гүйцэтгэхийг багийн ахлагч (Ч.Буянбадрах)-д үүрэг болгосугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Ж.ЦОЛМОН



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

Хариуцлагатай жижүүр томилох тухай

“Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасны дагуу Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын өдрүүдэд 2024 оны 07 дугаар сарын 10-ний өдрийн 06.00 цагаас эхлэн 2024 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 06.00 цаг хүртэлх 6 хоногийн хугацаанд хариуцлагатай жижүүр томилох зорилгоор ТУШААХ нь:

1. Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын өдрүүдэд Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албанаас ажиллах хариуцлагатай жижүүрийн ажлын удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Баярын өдрүүдэд үндсэн үүрэгт ажил болон нислэг техникийн осол, зөрчлийн талаар дүрмийн дагуу мэдээ, мэдээллээр хангахыг хариуцлагатай жижүүрт үүрэг болгосугай.

3. Баярын өдрүүдэд ажилласан хариуцлагатай жижүүрт хяналт тавьж ажиллах, энэ хугацаанд гарсан мэдээ, мэдээллийг нэгтгэж танилцуулахыг Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны ахлах шинжээч Х.Наранхүүд даалгасугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Ж.ЦОЛМОН